

**БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГАД НЭР ДЭВШҮҮЛЭХ ТУХАЙ АСУУДЛААР
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Р.Гончигдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хууль зүйн байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг тус Байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гаргаж байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Шаравдоржийн Түвдэндоржийг Хууль зүйн байнгын хорооны даргаар улируулан сонгуулахаар нэр дэвшүүлсэн бөгөөд өөр нэр дэвшигчийн талаар санал гараагүй болно.

Уг асуудлыг хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Х.Тэмүүжин нар нэр дэвшигчийг дэмжиж, тус Байнгын хороо нь хууль зүйн салбарт хийгдэж буй шинэчлэлийг түлхэн, манлайлан ажиллах ёстойг анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ, Ц.Оюунбаатар нар өөр нэр дэвшигчийг буюу өмнө хуульчаар ажиллаж байсан хүнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлж байсан болно. Түүнчлэн хуралдаанд Ардчилсан намын бүлгийн ахлагч Д.Эрдэнэбат Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Түвдэндорж нь биеийн эрүүл мэндийн байдлаас болж энэ жилийн хувьд зарим чуулганы болон Байнгын хорооны хуралдаанд биечлэн оролцож чадаагүй бөгөөд одоо энэхүү шалтгаан нь арилсан, мөн түүний улс төр, эрх зүйн салбарт мэргэшсэн байдал зэргийг харгалзан Байнгын хорооны даргын ажлыг үргэлжлүүлэн хийх боломжтой гэж үзсэн талаар тайлбар хийсэн болно.

Ш.Түвдэндоржийг Хууль зүйн байнгын хорооны даргаар улируулан сонгуулахаар нэр дэвшүүлэх саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэгт заасныг үндэслэн тус Байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүн Ш.Түвдэндоржийг Байнгын хорооны даргаар улируулан сонгуулахаар нэр дэвшүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлаар гарсан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ